



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/01-НА-СТА-ТӨА

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:Enkhtuyach@audit.gov.mn">Enkhtuyach@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:Batmunkhb@audit.gov.mn">Batmunkhb@audit.gov.mn</a>
2024 он	Аудитор: Б.Наранцэцэг Утас: 7036-3047 Цахим хаяг: <a href="mailto:Narantsetsegba@audit.gov.mn">Narantsetsegba@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № СЭА-2024/01-НА-СТА-704  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан ёдох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн авлагын дансанд насжилт өндөртэй, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй 1 иргэний 3,374.7 мянган төгрөгийн, 4 аж ахуйн нэгж, байгууллагын 14,563.2 мянган төгрөгийн зэрэг нийт **17,937.9** мянган төгрөгийн авлага, өр төлбөрийн дансанд 2009 онд Кувейтийн сангийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн автомашин, тоног төхөөрөмжийн үнийн **325,147.9** мянган төгрөгийн өр төлбөр тус тус бүртгэлтэй байна.

Актлагдаж бүртгэлээс хасагдсан Газ-53, Зил 130, Маз зэрэг автомашинуудын 2,498.7 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл эргэлтийн хөрөнгийн сэлбэг хэрэгсэл дансанд бүртгэлтэй байна.

## **Аудитын гол асуудал**

2023 оны хаваржилт, өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч, өвс тэжээлгүй болсны улмаас хонь, ямаа, үхэр олон тоогоор хорогдсон гэх үндэслэлээр Зүүнбүрэн сумын малын эмчийн тодорхойлолт, 3 дугаар багийн засаг даргын албан бичиг, компанийн Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр зэргийг үндэслэн мал амьтад дансанд бүртгэлтэй байсан бүх малыг буюу нийт 19,428.4 мянган төгрөгийн өртөг бүхий 149 тоо толгой малыг данс бүртгэлээс хассан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>910,198,174.99</b>	<b>874,138,377.32</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>348,296,175.96</b>	<b>384,177,759.91</b>
<b>31100</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>582.14</b>	<b>217,649.17</b>
31110	Төгрөг	582.14	217,649.17
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>348,295,593.82</b>	<b>383,960,110.74</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	348,295,593.82	383,960,110.74
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>296,626,151.17</b>	<b>250,866,760.67</b>
33401	Дансны авлага /ТӨҮГ/	296,626,151.17	250,866,760.67
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>265,275,847.86</b>	<b>239,093,856.74</b>
35300	Бэлэн бүтээгдэхүүн	265,275,847.86	239,093,856.74
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>875,943,672.08</b>	<b>876,972,297.41</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>875,943,672.08</b>	<b>876,972,297.41</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>573,401,672.08</b>	<b>574,430,297.41</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	420,834,755.11	420,834,755.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	-83,199,980.83	-104,170,723.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,143,776,556.19	1,082,683,638.74
39204	Хуримтлагдсан элэгдэл	-976,140,421.39	-888,179,331.31
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	470,381,367.74	493,135,822.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	-406,836,541.32	-433,633,719.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,661,276.24	27,661,276.24
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,528,150.81	-24,346,557.54
39214	Бусад үндсэн хөрөнгө	460,485.90	460,485.90
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,674.75	-15,349.53
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>302,542,000.00</b>	<b>302,542,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	304,942,336.00	304,942,336.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-2,400,336.00	-2,400,336.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,786,141,847.07</b>	<b>1,751,110,674.73</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>414,998,509.50</b>	<b>333,561,931.45</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>89,850,624.50</b>	<b>8,414,046.45</b>
<b>41200</b>	<b>Богино хугацаат зээлийн өглөг</b>	<b>1,352,600.00</b>	<b>0</b>
<b>41210</b>	<b>Төгрөг</b>	<b>1,352,600.00</b>	<b>0</b>
41216	Арилжааны банк	1,352,600.00	0
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>88,498,024.50</b>	<b>8,414,046.45</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>88,498,024.50</b>	<b>8,414,046.45</b>
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	66,333,459.07	8,414,046.45
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	22,164,565.43	0
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>325,147,885.00</b>	<b>325,147,885.00</b>
<b>42200</b>	<b>Урт хугацаат зээл</b>	<b>325,147,885.00</b>	<b>325,147,885.00</b>
<b>42220</b>	<b>Гадаад валют</b>	<b>325,147,885.00</b>	<b>325,147,885.00</b>
42230	Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	325,147,885.00	325,147,885.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,371,143,337.57</b>	<b>1,417,548,743.28</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,371,143,337.57</b>	<b>1,417,548,743.28</b>
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	507,379,700.00	507,379,700.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	302,542,000.00	302,542,000.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>225,048,124.52</b>	<b>271,453,530.23</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-351,181,210.45	225,048,124.52
51220	Тайлант үеийн үр дүн	576,229,334.97	46,405,405.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	336,173,513.05	336,173,513.05
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,786,141,847.07</b>	<b>1,751,110,674.73</b>


## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	699,638,346.51	151,871,767.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	699,638,346.51	151,871,767.30
120	Нийтлэг татварын бус орлого	699,638,346.51	151,871,767.30
120002	Хүүгийн орлого	0.00	736,392.51
120009	Бусад орлого	3,636,363.63	909,090.91
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	2,347,699,015.50	2,940,915,929.51
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	1,651,697,032.62	2,790,689,645.63
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	123,409,011.54	105,466,361.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	123,409,011.54	105,466,361.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	123,409,011.54	105,466,361.59
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	123,409,011.54	105,466,361.59
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	49,400,738.37	86,572,579.32
210813	Бусад зардал /ТӨҮГ/	9,982,791.51	18,893,782.27
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	64,025,481.66	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	576,229,334.97	46,405,405.71
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	576,229,334.97	46,405,405.71

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	809,921,700.00	336,173,513.05	511,298,881.97	1,657,394,095.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-862,480,092.42	-862,480,092.42
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	809,921,700.00	336,173,513.05	-351,181,210.45	794,914,002.60
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
Тайлант үеийн үр дүн	0	0	576,229,334.97	576,229,334.97
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	809,921,700.00	336,173,513.05	225,048,124.52	1,371,143,337.57
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	809,921,700.00	336,173,513.05	225,048,124.52	1,371,143,337.57
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	809,921,700.00	336,173,513.05	225,048,124.52	1,371,143,337.57
Зарласан ногдол ашиг	0	0	0	0
Тайлант үеийн үр дүн	0	0	46,405,405.71	46,405,405.71
2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	809,921,700.00	336,173,513.05	271,453,530.23	1,417,548,743.28

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан



Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,596,204,267.32</b>	<b>3,229,372,951.31</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,596,204,267.32</b>	<b>3,229,372,951.31</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,596,204,267.32</b>	<b>3,229,372,951.31</b>
120002	Хүүгийн орлого	0	736,392.51
120009	Бусад орлого	45,571,005.00	1,900,586,895.80
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	2,550,633,262.32	1,328,049,663.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,244,818,643.17</b>	<b>3,108,221,458.27</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,244,818,643.17</b>	<b>3,108,221,458.27</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,244,818,643.17</b>	<b>3,108,221,458.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>454,889,068.00</b>	<b>773,919,529.00</b>
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	454,889,068.00	773,919,529.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>156,370,703.50</b>	<b>111,906,308.76</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	156,370,703.50	111,906,308.76
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>23,742,674.84</b>	<b>57,654,876.60</b>
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	23,742,674.84	57,654,876.60
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,191,415,657.19</b>	<b>1,424,067,922.12</b>
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	286,128,426.86	481,894,512.17
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	905,287,230.33	942,173,409.95
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>418,400,539.64</b>	<b>740,672,821.79</b>
210815	Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	7,457,650.45	1,505,968.17
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	301,000,000.00	154,583,036.90
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0	7,915,474.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	109,942,889.19	576,668,342.72
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>351,385,624.15</b>	<b>121,151,493.04</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>62,350,727.28</b>	<b>85,269,909.09</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>62,350,727.28</b>	<b>85,269,909.09</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>62,350,727.28</b>	<b>85,269,909.09</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	62,350,727.28	85,269,909.09
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-62,350,727.28</b>	<b>-85,269,909.09</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-4,050,000.00</b>	<b>0</b>
<b>25</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>4,050,000.00</b>	<b>0</b>
250005	Төлсөн ногдол ашиг	4,050,000.00	0
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>284,984,896.87</b>	<b>35,881,583.95</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	63,311,279.09	348,296,175.96
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	348,296,175.96	384,177,759.91

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэл</b>						
	А. Улсын чанартай авто замын засвар арчлалт	м/төг	642,006.0	650,000.0	442,507.9	207,492.1	68.1%
	Б. Орон нутгийн чанартай замын засвар арчлалт, бусад	м/төг	1,709,329.4	1,080,500.0	723,534.7	-356,965.3	67.0%
2	<b>Нийт орлого</b>	м/төг	<b>2,351,335.4</b>	<b>1,920,856.4</b>	<b>2,942,561.4</b>	1,021,705.0	153.2%
	А) Хайрга дайрганы орлого	м/төг		51,256.4	4,817.0	-46,439.4	9.4%
	Б) Гэрээний орлого	м/төг		139,100.0	1,771,701.8	1,632,601.8	1273.7%
3	<b>Нийт зардал</b>	м/төг	<b>1,711,080.4</b>	<b>1,908,595.4</b>	<b>2,896,156.0</b>	987,560.6	151.7%
	Үүнээс: Удирдлагын зардал	м/төг	<b>284,367.7</b>	<b>394,058.3</b>	<b>86,572.0</b>	307,486.3	22.0%
4	Татварын өмнөх ашиг, алдагдал	м/төг	640,255.0	12,261.0	46,405.4	34,144.0	378.5%
5	Цэвэр ашиг/ алдагдал	м/төг	576,229.3	11,034.9	41,764.5	30,729.6	378.5%
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м/төг	466,472.1	303,188.5	288,572.2	14,616.3	95.2%
	а) Орлогын албан татвар	м/төг	885.4	1,226.1	4,640.5	3,414.4	378.5%
	б) НӨАТ	м/төг	215,224.1	150,000.0	104,586.2	45,413.8	69.7%
	в) НДШ	м/төг	156,370.7	99,392.4	111,906.3	12,513.9	112.6%
	г) Хүн амын орлогын албан татвар	м/төг	75,019.2	48,000.0	54,431.7	6,431.7	113.4%
	д) Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	м/төг	1,729.5	1,800.0	2,492.0	692.0	138.4%
	ё) Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	м/төг	2,288.9	2,500.0	2,214.9	285.1	88.6%
	ж) бусад татвар	м/төг	6,194.9	270.0	2,783.2	2,513.2	1030.8%
7	Төрийн өмчийн ногдол ашиг	м/төг	8,759.4	5,517.4	5,517.4	-	100.0%
8	Нийт ажиллагсдын тоо	Хүн	50.0	57.0	55.0	-2.0	96.5%
9	Нийт цалингийн сан	м/төг	542,330.0	685,464.6	773,919.0	88,454.4	112.9%
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м/төг	903.9	1,002.1	1,172.6	170.5	117.0%
11	Борлуулалтын орлогын 1 төг ногдох зардал	Төг	0.7277	0.9936	0.98	0.0	99.1%
12	Хөрөнгө оруулалт	м/төг	62,351.0	93,417.0	93,417.0	-	100.0%
13	Нийт авлага	м/төг	40,871.8	101,272.3	250,866.7	149,594.4	247.7%
	Үүнээс: найдваргүй	м/төг	1,651.2	1,651.2	1,650.2	1.0	99.9%
14	Нийт өглөг	м/төг	623,777.1	432,913.6	333,561.9	99,351.7	77.1%
	Богино хугацаат өглөг	м/төг	298,629.2	107,765.7	8,414.0	99,351.7	7.8%
	Урт хугацаат өглөг	м/төг	325,147.9	325,147.9	325,147.9	-	100.0%

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь “Олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто зам болон төмөрбетон гүүр, хоолой зэрэг замын байгууламжийн засвар арчлалтын ажлыг хариуцаж, авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг байнга ханган ажиллах” гэсэн үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улсын чанартай авто замын засвар арчлалт, шугамын хэсгүүдийг шуурхай удирдлагаар хангаж, хариуцсан авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж, гарсан эвдрэл, гэмтлийг арилгах ажлыг зохион байгуулан, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх,
- Замын барилгын үйлдвэрлэл эрхэлж, тоног төхөөрөмж, машин механизмыг үр ашигтай ажиллуулах,
- Авто замын засвар, арчлалтын үйл ажиллагааг гүйцэтгэхдээ холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан авто замын урт, тэдгээрийн дагуу байрлах шугаман албадын байршил, засвар, арчлалтын ажлын нэгж, норм норматив, төсвийн норм, үнэлгээ болон түрээсийн тоног төхөөрөмжийн машин цагийн норм үнэлгээг мөрдөж ажиллах,
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй, орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх.

Тус ТӨХК нь 2023 онд нийт 113 км олон улсын болон улсын чанартай авто зам, гүүрийн засвар арчлалтын ажлыг гүйцэтгэх гэрээг “Зам тээврийн хөгжлийн яам”-тай байгуулан ажилласнаас гадна Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Ерөө, Цагааннуур сумд, Дулаанхан тосгоны авто замын шинэчлэл болон зам засвар, тэмдэг тэмдэглэгээний ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.


#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант онд “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 10 гишүүний цалинд нийт 39,300.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2023 онд 8 удаа зохион байгуулж, 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хэлэлцэх, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний болон гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэх, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон гэх мэт.
- ТУЗ-ийн 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн захирлын цалинг 4,620.0 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэн байна.



### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь 2016 онд боловсруулагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Уг НБББББ-ийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн 2016 оноос хойш холбогдох хууль, эрхийн актууд, стандартад тодорхой хэмжээний нэмэлт, өөрчлөлт орсон тул эдгээрт нийцүүлэн бодлогын бичиг баримтыг шинэчлэн боловсруулах нь зүйтэй юм.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд


“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Нийт хөрөнгө өмнөх оноос 35,031.1 мянган төгрөгөөр буурсан нь авлага, бараа материал, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарснаас шалтгаалсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	348,296.2	384,177.8	35,881.60
Авлага	296,626.1	250,866.8	-45,759.30
Бараа материал	265,275.8	239,093.8	-26,182.00
Үндсэн хөрөнгө	875,943.7	876,972.3	1,028.60
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,786,141.8</b>	<b>1,751,110.7</b>	<b>-35,031.10</b>
Өр төлбөр	414,998.5	333,561.9	-81,436.60
Эздийн өмч	1,371,143.3	1,417,548.7	46,405.40

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,786,141.8	1,751,110.7	-35,031.10
--	-------------	-------------	------------



Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл 45,759.3 мянган төгрөгөөр буурсан нь Цагааннуур сумын ОНХС-аар он дамжин хийгдсэн “Гэр чулууны давааны авто зам засвар”-ын ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгснөөс,
- Бараа материалын данс 26,182.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны гэрээт ажлыг хийж гүйцэтгэн бараа материал зарцуулснаас,
- Өр төлбөр данс 81,436.6 мянган төгрөгөөр буурсан нь НӨАТ болон ХХОАТ-ын өглөгийг тайлант онд барагдуулснаас голлон шалтгаалсан байна.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн авлагын дансанд насжилт өндөртэй, тооцос нийлсэн актаар баталгаажаагүй 1 иргэний 3,374.7 мянган төгрөгийн, 4 аж ахуйн нэгж, байгууллагын 14,563.2 мянган төгрөгийн зэрэг нийт 17,937.9 мянган төгрөгийн авлага, өр төлбөрийн дансанд 2009 онд Кувейтийн сангийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн автомашин, тоног төхөөрөмжийн үнийн 325,147.9 мянган төгрөгийн өр төлбөр тус тус бүртгэлтэй байна.

Бараа материалын дансанд актлагдаж бүртгэлээс хасагдсан Газ-53, Зил 130, Маз зэрэг автомашинуудын 2,498.7 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл бүртгэлтэй байна.

### 3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 болон 20 дугаар зүйлийн 20.3-д заасны дагуу “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь компанийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 574 дүгээр тогтоолоор “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 1,920,900.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,908,595.4 мянган төгрөгөөр, цэвэр ашгийг 11,034.9 мянган төгрөгөөр тус тус тогтоож, хөрөнгө оруулалтын 7 арга хэмжээнд нийт 93,417.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2,942,561.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,896,156.0 мянган төгрөгийн зардал гарган, 46,405.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

2023 онд Зам тээврийн яамнаас улсын болон орон нутгийн чанартай зам засвар арчлалтын санхүүжилтийн орлого 1,166,042.6 мянган төгрөг, орон нутгийн зам засварын ажлын тендерийн орлого 1,646,067.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 130,451.1 мянган төгрөг /*дайрга бутлуур, гэрээгээр хийгдсэн бусад ажил үйлчилгээ*/ зэрэг нийт 2,942,561.4 мянган төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлжээ.

Нийт орлогын гүйцэтгэл 2,942,561.4 мянган төгрөг болж төлөвлөгөөг 1,021,705.0 мянган төгрөгөөр буюу 1.5 дахин давуулан биелүүлсэн нь орон нутгийн зам засварын гэрээт ажлын орлогоос голлон шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,896,156.0 мянган төгрөг болж төлөвлөснөөс 987,560.6 мянган төгрөг буюу 65.9 хувиар хэтэрсэн нь орон нутгийн зам засварын ажлын гүйцэтгэл төлөвлөснөөс эрс нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

*Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.*

### **3.6. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь ТӨБЗГ-аас баталсан 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу дараах 4 худалдан авах ажиллагааг tender.gov.mn цахим сайтаар нээлттэй зарласан байна. Үүнд:

- 115,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Битум шингэн худалдан авах”,
- 270,440.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Шатахуун худалдан авах”,
- 27,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Автогрейдерийн кроп худалдан авах”,
- 68,767.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Крантай ачааны машин худалдан авах” гэх мэт.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг харьцуулалтын болон нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулж, гүйцэтгэгчтэй “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулан ажилласан байна. Үүнд:

- “Битум шингэн худалдан авах” нээлттэй тендер шалгаруулалтыг 3 удаа зохион байгуулсан боловч тендерийн материал ирээгүй тул Дивитас, Си Ди Энержи зэрэг компаниудаас шууд гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн,
- “Шатахуун худалдан авах”- ажиллагааны нээлттэй тендер шалгаруулалтад 2 компани санал ирүүлснээс 259,757.5 мянган төгрөгийн буюу хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Шунхлайпетролиум” ХХК-ийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан,
- “Автогрейдерийн кроп худалдан авах” харьцуулалтын аргын сонгон шалгаруулалтад 2 компани санал ирүүлснээс техникийн тодорхойлолтод тавигдах шаардлагыг бүрэн хангасан “Хазаарбат” ХХК-ийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан,
- “Крантай ачааны машин худалдан авах” харьцуулалтын аргын сонгон шалгаруулалтад “Бүрэн баян булаг” ХХК санал ирүүлж, шаардлага хангасан тул гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж, тус тус худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн байна.

## 4. Аудитын тайлан

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж, аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилулав.

Мөн хөрөнгийн тооллого, татварын тайлантай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь 2023 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,775,106.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **17,751.1** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллагын зүгээс дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хэвлэл захиалга хийгээгүй, сургалтыг цахимаар зохион байгуулж албан томилолтын зардлыг хэмнэсэн,
- Ажилчдын утасны зардлын хэмжээг бууруулсан,
- Аймгийн шагналаар шагнагдсан 16 ажилтанд мөнгөн шагнал олгоогүй,
- Шинэ жилийн арга хэмжээг хийгээгүй, гарын бэлэг олгоогүй,
- Авлага, өр төлбөрийг бууруулах арга хэмжээ авсан гэх мэт.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.



##### 4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь тайлант хугацаанд шилэн дансанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 152 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө- 1 дүгээр сард,
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт-1 дүгээр сард,
- Дараа жилийн зорилтот түвшин-9 дүгээр сард,
- Худалдан авах ажиллагааны тайлан-1 дүгээр сард гэх мэт.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 124 дүгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 434.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,563.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 8,706.6 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	434.7	1	434.7	100
Албан шаардлага	1	1,563.0	1	1,563.0	100

Зөвлөмж	2	8,706.6	2	8,706.6	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>10,704.3</b>	<b>4</b>	<b>10,704.3</b>	<b>100</b>

#### 4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлын улмаас шатахууны тооцоо болон борлуулсан бүтээгдэхүүний өртгийг үнэн зөв толилуулсан эсэхийг шалгах боломжгүй байсан учир дараагийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах нь зүйтэй юм.

#### 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой дараах **854,740.0** мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайланд 2,000.0 мянган төгрөгийн түрээсийн авлагыг тайлагнаагүй,
- НӨАТ-ын тайланд 842,000.0 мянган төгрөгийн орлого дутуу тайлагнасан,
- Нийгмийн даатгалын тайланд 7,680.9 мянган төгрөгийн цалин илүү тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайланд цалингийн зардлыг 3,059.1 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн гэх мэт.

Аудитаар нийт **23,735.0** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс **500.0** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **2,841.1** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх **20,393.9** мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

##### 5.1 Төлбөрийн акт

**5.1.1.** Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан жолооч Э.Ганбатын 150.0 мянган төгрөгийн, кассын нярваар ажиллаж байсан Б.Мөнхгэрэлийн 350.0 мянган төгрөгийн зэрэг нийт **500.0** мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Суутгаагүй цалингийн урьдчилгааг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

##### 5.2 Албан шаардлага

**5.2.1.** Тус компанийн ажилтан дараах 5 хүний ээлжийн амралтыг биеэр эдлүүлэлгүйгээр нийт **1,478.1** мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д "Ажилтан

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ.” гэж заасныг зөрчсөн байна. Үүнд:

- Механик Д.Ганзориг -185.4 мянган төгрөг,
- Нярав О.Цэнгэл - 144.0 мянган төгрөг,
- Харуул Д.Манлайбаатар – 525.2 мянган төгрөг,
- Жолооч О.Үнэнбаяр – 285.2 мянган төгрөг,
- Жолооч Б.Анхбаяр – 338.3 мянган төгрөг.



Шийдвэрлэсэн нь: Цаашид ээлжийн амралтыг биеэр эдлүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.2.2.** Төрийн өмчийн барилгыг “Юнител” ХХК-д түрээслүүлсний орлогын 40 хувь болох **400.0** мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй нь ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолын 3-т “Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүнгийн 40 /дөчин/ хувиар тогтоосугай” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн орлогыг тухай бүр тогтоосон хувь хэмжээгээр тооцон төсөвт төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.2.3.** Цахим тендер шалгаруулалтын орлогын 210.0 мянган төгрөг, улсын тэмдэгтийн хураамжийн буцаан олголтын 753.0 мянган төгрөг зэрэг нийт **963.0** мянган төгрөгийг тус компанид кассын нярваар ажиллаж байсан Б.Мөнхгэрэлээс авах авлагад суутган тооцож, авлагыг бууруулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд залруулж, үлдэгдлийг бодитоор илэрхийлж, барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

#### **Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Улаанбаатар болон сумдад албан томилолтоор ажилласан ажилтнуудын томилолтын зардлыг ажилтан тус бүрээр авлага, өглөг үүсгэлгүйгээр, тухай бүр 1 хүний дансанд бөөн дүнгээр буюу нийт **13,451.6** мянган төгрөгийг шилжүүлэн шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Албан томилолтын зардлыг тухай бүр ажилтан тус бүрээр тооцоо үүсгэн, бүртгэж байх.

### **Эргэлтийн хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал**

Илрүүлэлт: Захирлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/27 дугаар тушаалаар томилогдсон “Тооллогын комисс” нь үндсэн хөрөнгийн үлдэгдлийг тоолж баталгаажуулсан боловч бараа материалын болон касс дахь бэлэн мөнгөний үлдэгдлийн тооллогыг хийж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1: “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг бүрэн хийж гүйцэтгэж байх.

### **Татварын тайлантай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Татварын тайланд 3 ажилтны цалинг илүү, 6 ажилтны цалинг дутуу зэрэг нийт **6,942.3** мянган төгрөгийн цалинг дутуу тайлагнасан болон татварын хөнгөлөлтийн тооцооллыг хийгээгүй нь ХХОАТ-ын авлага, өр төлбөр үүсгэх эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Татвар ногдох орлогод дараах орлого хамаарна” 6.3.1-д “Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Татварын хөнгөлөлтийн тооцоолол болон зөрүүтэй тайлагнасан цалинг 2024 оны татварын тайланд залруулж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
	Нийт зөрчил		Төлбөр-ийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Түрээсийн авлагыг дутуу тусгасан	1	2,000.0					1	2,000.0	1	2,000.0		
НӨАТ-ын тайланд орлого дутуу тайлагнасан	1	842,000.0					1	842,000.0	1	842,000.0		
Нийгмийн даатгалын тайланд цалин илүү тайлагнасан	1	7,680.9					1	7,680.9	1	7,680.9		
Үр дүнгийн зардалд цалингийн зардлыг дутуу тайлагнасан	1	3,059.1					1	3,059.1	1	3,059.1		
Нийт дүн	4	854,740.0					4	854,740.0	4	854,740.0		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөр-ийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Цалингийн урьдчилгааг суутгаагүй	1	500.0	1	500.0							
Эзлэгийн амралтын биеэр эдлүүлээгүй	1	1,478.1			1	1,478.1						
Түрээсийн орлогыг төвлөрүүлээгүй	1	400.0			1	400.0						
Үндэслэлгүйгээр авлага хаасан	1	963.0			1	963.0						



/мянган төгрөгөөр/

/мянган төгрөгөөр/

Албан томилолтын зардлыг шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн	1	13,451.6					1	13,451.6
Няравын агуулах дахь материалын болон касс дахь бэлэн мөнгөний үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй	1						1	
Татварын тайланд цалинг зөрүүтэй тайлагнасан	1	6,942.3					1	6,942.3
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>23,735.0</b>	<b>1</b>	<b>500.0</b>	<b>3</b>	<b>2,841.1</b>	<b>3</b>	<b>20,393.9</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн					1	
<b>Дүн</b>					<b>1</b>	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
<b>Дүн</b>						
<b>Нийт дүн</b>					<b>1</b>	

